

МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
УРЬДЧИЛАН МЭДЭЭЛЭХ ХЭЛТЭС

2023 оны 04 дугаар сарын 17

Улаанбаатар хот 46
Жуулчны гудамж – 5

Утас: 326609, 326603
Факс: 326614, 263862

Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх тухай

2023 оны 4 дүгээр сарын 17-18-нд шилжих шөнө Баян-Өлгийн нутгаар хүчтэй салхины **Аюултай үзэгдэл**, 18-ний өдөр Увсын өмнөд, Ховдын хойд, Говь-Алтайн баруун болон хойд хэсгээр хүчтэй салхи, шороон шуурганы **Гамшигт үзэгдэл**, Завхан, Архангайн нутаг, Баян-өлгийн хойд, Ховдын өмнөд, Баянхонгорын баруун хэсгээр хүчтэй салхины **Аюултай үзэгдэл**, Завхан, Баянхонгор, Архангай, Өвөрхангайн нутаг, Хөвсгөл, Булганы өмнөд хэсгээр шороон шуурганы **Аюултай үзэгдэл** ажиглагдана.

Хүчтэй салхины аюултай үзэгдлийн үеэр салхи секундэд 18-20 метр, зарим үед 24-ийг давж, Гамшигт үзэгдлийн үеэр салхи секундэд 24-28 метр, зарим үед 34-ийг давж салхилна. Шороон шуурганы үер үзэгдэх орчин 1000м ээс бага болж хязгаарлагдана.

Мөн энэ үеэр баруун аймгуудын нутгийн баруун болон хойд хэсгээр нойтон цас, цас орж, цасан шуурга шуурч, өмнөх хоногоосоо 10-15 градусаар эрс хүйтрэхийг онцгойлон анхааруулж байна.

Ийм үзэгдлийн үеэр эрчим хүчний шон унах, хашаа, байшин нурах, зам, даваа цас, шороонд хаагдах, үзэгдэх орчин хязгаарлагдах, хээр, гадаа явах тохиолдолд осгох, хайрагдах зэрэг эрчим хүч, зам тээвэр, мал аж ахуйн салбарт ноцтой хүндрэл учруулахуйц эрсдэлтэй тул байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүмүүс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авахыг хүсье.

Энэхүү үзэгдлийн эрч хүч хэвээр хадгалагдан 19-нд төв, зүүн, говийн аймгуудын нутгаар, 20-нд зүүн аймгуудын нутгаар дайран өнгөрөх тул тус аймаг, орон нутгийн иргэд, байгууллагууд цаг агаарын мэдээгээ тухай бүр хүлээн авч бэлтгэл бэлэн байдлаа хангахыг зөвлөж байна.

Харанга!!! Цаг агаарын гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ:

Маргааш өдөр Увсын өмнөд, Говь-Алтайн баруун болон хойд, Ховдын хойд хэсгээр салхи секундэд 24-28 метр, зарим үед секундэд 34 метрийг давж хүчтэй салхи салхилж, шороон шуурга шуурна.

Дохио!!! Цаг агаарын аюултай үзэгдлээс сэрэмжлүүлэх мэдээ :

Өнөө шөнө Баян-Өлгийн хойд хэсгээр, маргааш өдөр Завхан, Архангайн нутаг, Баян-өлгийн хойд, Ховдын өмнөд, Баянхонгорын баруун хэсгээр салхи секундэд 18-20 метр, зарим үед 24 метрийг давж ширүүсэж, Завхан, Баянхонгор, Архангай, Өвөрхангайн нутаг, Хөвсгөл, Булганы өмнөд хэсгээр шороон шуурга шуурна.

Малчид, иргэд, тээвэрчдийн анхааралд:

Өнөө шөнө баруун аймгуудын нутгаар, маргааш өдөр ихэнх нутгаар, 19-нд төв, зүүн, говийн аймгуудын нутгаар, 20-нд зүүн аймгуудын нутгаар хүчтэй салхи, шороон болон цасан шуургатай байхыг онцгойлон анхааруулж байна.

Дэлгэрэнгүйг: <http://alarm.tsag-agaar.gov.mn/>

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР